

## БАЙГУУЛЛАГЫН ДОТООД АУДИТЫН 2022 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 05

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын дэргэдэх Дотоод аудитын хорооны 2017 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын журам”, байгууллагын дотоод аудитын 2022 оны төлөвлөгөөний дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

### Нэг. Төсөв, санхүүгийн чиглэлээр

Дотоод аудитын 2022 оны төлөвлөгөөний дагуу санхүүгийн болон үйл ажиллагааны чиглэлээр 3, нийцлийн чиглэлээр 7, нийт 10 удаагийн төлөвлөгөөт дотоод аудитын шалгалт хийж, төв болон боомт, орон нутаг дахь нэгжүүдэд 7 удаагийн аудитын зөвлөмж хүргүүлэн хяналт тавин ажиллалаа.

Хяналт шалгалтыг төрлөөр нь ангилвал:

Д/д	Хяналт, шалгалтын төрөл	Хамрагдсан байгууллагын нэр	Хяналт шалгалтын тоо	Тайлбар
1	2	3	4	5
1	Санхүүгийн болон үйл ажиллагааны чиглэлээр аудит	Захиргаа, удирдлагын газар	1 удаа	Төлөвлөгөөт
2		Дорноговь аймаг дахь газар	1 удаа	Төлөвлөгөөт
3		Өмнөд бүс дэх газар	1 удаа	Төлөвлөгөөт
4	Нийцлийн аудит /Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, батлан гаргасан шийдвэр/ тушаал	Захиргаа, удирдлагын газар	1 удаа	Төлөвлөгөөт
5		Дорноговь аймаг дахь газар	1 удаа	Төлөвлөгөөт
6		Өмнөд бүс дэх газар	1 удаа	Төлөвлөгөөт
7		Төв болон боомт, орон нутаг дахь нэгжүүд	4 удаа	Төлөвлөгөөт

Байгууллагын даргын баталсан 3 удаагийн удирдамжийн дагуу Захиргаа, удирдлагын газрын 2021 оны хүний нөөцийн үйл ажиллагаа, Дорноговь аймаг дахь газар болон Өмнөд бүс дэх газрын 2021 он, 2022 оны эхний гуравдугаар улирлын санхүүгийн тайланд дотоод аудитын шалгалт хийж, дүнг 01/10/04, 01-10/08, 01-09/16 дугаар илтгэх хуудсаар байгууллагын удирдлагад танилцуулав.

### Хоёр. Нийцлийн аудитын чиглэлээр

Байгууллагын даргын баталсан 3 удаагийн удирдамжийн дагуу Захиргаа, удирдлагын газрын 2021 оны хүний нөөцийн үйл ажиллагаа, Дорноговь аймаг дахь

газар болон Өмнөд бүс дэх газрын даргын 2021 он, 2022 оны эхний гуравдугаар улирлын байдлаар батлан гаргасан тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд дотоод аудитын шалгалтыг хийж, дүнг 01/10/04, 01-10/08, 01-09/16 дугаар илтгэх хуудсаар байгууллагын удирдлагад танилцуулсан.

Шилэн дансны тухай хуулийн 2021 оны IV улирал, 2022 оны I-III улирлын хэрэгжилтэд байгууллагын даргын баталсан 4 удаагийн удирдамжийн дагуу дотоод аудитын шалгалт хийж, шалгалтын дүнг 01-10/01, 01-10/07, 01-10/13, 01-09/15 дугаар илтгэх хуудсаар байгууллагын удирдлагад танилцуулж, төв болон боомт, орон нутаг дахь нэгжүүдэд 7 удаагийн аудитын зөвлөмж хүргүүлэн, биелэлтийг хангуулан ажиллалаа. Тус хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд зохион байгуулалтын нэгжүүдийн байршуулсан 2022 оны сар бүрийн мэдээлэлд хяналт тавин ажиллаж байна.

Хууль зүй, дотоод хэргийн яаманд Шилэн дансны тухай хуулийн 2022 оны I-III улирал болон эхний хагас жилийн тайланг 03/221, 03/1259, 02/1751 дугаар албан бичгээр, Үндэсний аудитын газрын 2021 оны санхүүгийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгах зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 01/1216 дугаар албан бичгээр тус тус хүргүүлж тайлагналаа.

#### Гурав. Бусад асуудлаар

Байгууллагын дотоод аудитын 2021 оны ажлын тайлан, 2022 оны төлөвлөгөөний төслийг 2021 оны 03/23 дугаар албан бичгээр, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс болон дотоод аудитын 2022 оны эхний хагас жилийн тайланг 03/1160 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 1/1856 дугаар зөвлөмжийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр байгууллагын 2021 оны үнэлгээ, эрсдлийг Даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулж, байгууллагын даргаар 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдөр Эрсдлийг сааруулах үйл ажиллагаа буюу хариу арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Байгууллагын 2021 оны эрсдэлийн тайланг 12 дугаар сард 01/1747 дугаар албан бичгээр, 2022 оны эхний хагас жилийн эрсдэлийн тайлан болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөмжийн хэрэгжилтийг 06 дугаар сард 01/1135 дугаар албан бичгээр, 2022 оны эрсдэлийн тайланг 12 дугаар сард 01/2087 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, эрсдэлийн мэдээллийн цахим сан ([mojha.unelgee.gov.mn](http://mojha.unelgee.gov.mn))-д эрсдэлийг үнэлж, тайлагнан баталгаажуулалтыг хийв.

Цахим хөгжлийн багц хуулиудыг хэрэгжүүлэхэд бусад хуулиудтай тулгамдаж буй асуудлыг тодорхойлсон судалгаа, хэрэгжүүлэх талаарх танилцуулгыг 2022 оны 09 дүгээр сард 01/1654, 01/1667 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хоёр удаагийн хуралд хэлтсийн дарга, нийцлийн аудит хариуцсан ахлах мэргэжилтэн нар оролцон үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлийн хугацаа дуусч, элэгдлээрээ балансын өртгөө нөхсөн актлах болон дахин ашиглах боломжтой хөрөнгийн жагсаалтад хяналт тавин ажиллалаа.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ  
АУДИТЫН ХЭЛТЭС